

“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү мэдээллийн үйл ажиллагааны журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь “Түмэн шувуут” хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-аас эрх бүхий байгууллагуудад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд өгөх хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Компанийн мэдээллийн үйл ажиллагаа нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх), Монголын үнэт цаасны бирж (цаашид “Бирж” гэх)-ийн журам, тогтоол, заавар болон Компанийн дотоод журамд нийцсэн байна.
- 1.3 Энэхүү Журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1 “Мэдээллийг нээлттэй болгох” гэж үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг Компанийн болон Биржийн цахим хуудас, Хорооноос шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бусад олон нийтийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг;
 - 1.3.2 “Тухай бүр мэдээлэх” гэж үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа мэдээллийг Компанийн болон Биржийн цахим хуудас, Хорооноос тогтоосон бусад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэхийг;
 - 1.3.3 “Дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д болон Хорооны “Үнэт цаасны дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчээс үнэт цаасны зах зээл дээр явуулах үйл ажиллагааны тухай” журамд заасан этгээдийг;
 - 1.3.4 “Хугацаат тайлан” гэж үнэт цаас гаргагчаас хувьцаа эзэмшигчдийн хуралд болон хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэсэн, өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг агуулсан баримт бичгийг.

ХОЁР. НИЙТЭД МЭДЭЭЛЛИЙГ ТОГТМОЛ ХҮРГЭХ

- 2.1 Компанийн нийтэд мэдээлэх хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.
- 2.2 Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тус тус энэ журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.
- 2.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:
 - 2.3.1. *Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:*
 - 2.3.1.1. компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;

- 2.3.1.2. компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;
 - 2.3.1.3. тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;
 - 2.3.1.4. компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан
 - 2.3.1.5. нийгмийн хариуцлагын тайлан.
 - 2.3.2. **Удирдлагын талаарх мэдээлэл:**
 - 2.3.2.1. компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;
 - 2.3.2.2. компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;
 - 2.3.2.3. компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;
 - 2.3.2.4. ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан;
 - 2.3.2.5. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;
 - 2.3.2.6. Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан.
 - 2.3.3. **Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:**
 - 2.3.3.1. компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;
 - 2.3.3.2. аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар, тодруулга, дүгнэлт;
 - 2.3.3.3. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;
 - 2.3.3.4. тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа;
 - 2.3.3.5. жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл.
 - 2.3.4. **Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:**
 - 2.3.4.1. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэр;
 - 2.3.4.2. компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч /бенефициар эзэмшигч/ этгээдийн талаарх мэдээлэл;
 - 2.3.5. **Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;**
 - 2.3.5.1. компанийн эрх бүхий албан тушаалтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бусад компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл;
 - 2.3.5. **Ногдол ашгийн талаарх мэдээлэл;**
 - 2.3.5.1. компанийн ногдол ашгийн бодлого;
 - 2.3.5.2. компанийн тухайн жилд хувиарласан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хувиарлаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл.
 - 2.3.6. **Бусад шаардлагатай мэдээлэл;**
 - 2.3.6.1. энэ журамд заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл;
 - 2.3.6.2. компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.
- 2.4 Компани нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргаж, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор Хөрөнгийн биржид хүргүүлнэ.
- 2.5 Компани нь хорооноос зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан тайланг тайлант жил дууссанаас хойш 04 дүгээр сарын 01-ны дотор Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлнэ.

- 2.6 Хугацаат тайлангийн мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд бэлтгэж бүрдүүлэх хариуцлагыг Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч зэрэг холбогдох ажил харицсан албан тушаалтан, түүнийг олон нийтэд мэдээлэх ажлыг ТУЗ-ын нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд мэдээллийг олон нийтэд үнэн зөв, шуурхай хүргэж ажиллахад Компанийн удирдлага бүх талаар дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
- 2.7 Хэрэв Компанийн хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нийтэд мэдээлэхээс өмнө Компанийн ашиг, алдагдлын хэмжээ нийтэд тархаж, энэ нь Компанийн гаргасан үнэт цаасны үнэ ханш 15-аас багагүй хувиар өөрчлөгдөхөд хүргэсэн бол Компани тухайн тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн талаар нэн даруй нийтэд мэдээлэх арга хэмжээ авна.
- 2.8 Компанийн үйл ажиллагааны тайланд Компанийн засаглалын тайлан, Компанийн засаглалын кодексийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар заавал тусгасан байна.

ГУРАВ. ТУХАЙ БҮР МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХ

- 3.1. Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдад үндэслэл бүхий шийдвэр гаргахад шаардлагатай, үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлагын бүтэц, зохион байгуулалттай холбоотой мэдээллийг тухай бүр Компанийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 3.2. Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:

3.2.1. Санхүүгийн мэдээлэл:

- 3.2.1.1. компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;
- 3.2.1.2. компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгох;
- 3.2.1.3. компани хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл
- 3.2.1.4. сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;
- 3.2.1.5. компанийн үл хөдлөх хөрөнгийн дүнийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;
- 3.2.1.6. компани төлбөрийн чадваргүй болох
- 3.2.1.7. компанийн толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;
- 3.2.1.8. компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах.

3.2.2. Санхүүгийн бусад мэдээлэл

- 3.2.2.1. компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;
- 3.2.2.2. компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;
- 3.2.2.3. компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц болон шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;
- 3.2.2.4. үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;
- 3.2.2.5. компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байгаа хаяг байршил өөрчлөгдсөн;

- 3.2.2.6. компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;
- 3.2.2.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт;
- 3.2.2.8. нийт ажиллагсадын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;
- 3.2.2.9. компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон;
- 3.2.2.10. компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл/лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн;
- 3.2.2.11. компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох;
- 3.2.2.12. хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;
- 3.2.2.13. компанийг нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах зэргээр өөрчлөн байгуулах болон өөрчлөх шийдвэр;
- 3.2.2.14. компанийн хувьцааг хуваах, нэгтгэх тухай шийдвэр;
- 3.2.2.15. компанийг татан буулгах шийдвэр.

3.2.3 Удирдлагын талаарх мэдээлэл:

- 3.2.3.1. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар, болон хурлаас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт материал
- 3.2.3.2. компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;
- 3.2.3.3. компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт;
- 3.2.3.4. компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;
- 3.2.3.5. компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлсэн нь шүүхээр тогтоогдсон.

3.2.4 Байгаль, орчин, нийгэм, засаглал /цаашид БОНЗ гэх/-ын талаарх мэдээлэл:

- 3.2.4.1 Тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц удирдлага, тайлагнал болон гишүүнчлэлтэй холбоотой асуудлууд
- 3.2.4.2 Эрчим хүч, хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлт, ус, хөг хаягдал, биологийн төрөл зүйл зэрэг асуудлууд
- 3.2.4.3 Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, жендэрийн эрх тэгш байдал, хүртээмж, олон нийтийн харилцаа, худалдан авалтын бодлого зэрэг асуудлууд
- 3.2.4.4 Авилга, хээл хахууль, компанийн засаглал, комплайнс, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлууд
- 3.2.4.5 Банк санхүү, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилга, уул уурхай зэрэг салбарт үйл ажиллагаа явуулж буй компанид тусгайлан хамаарах асуудлууд

3.3. Компаниас тухай бүр нийтэд нээлттэй болгох мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 2 өдөрт багтаан Компанийн болон Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ. Компани нь энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийг нээлттэй болгохдоо Хороо, Биржид тухайн асуудлаар гарсан албан ёсны шийдвэрийг ажлын 1 өдөрт багтаан хүргүүлнэ.

3.4. Компани нь энэхүү журмын 3.2-т заасан болон бусад мэдээллийн агуулга, хэлбэр, нийтэд

мэдээлэх журмыг Биржтэй байгуулсан гэрээнд тусган мөрдөж ажиллана.

- 3.5. Энэхүү журмын 3.2-т заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, Биржийн цахим хуудсанд тавих этгээд нь Компанийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга байх бөгөөд тухайн ажилтан болон Гүйцэтгэх захирал тухайн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.
- 3.6. Компанийн үнэт цаасны үнэ ханш, арилжааны хэмжээнд огцом өөрчлөлт гарсан, арилжаа түр зогссон тохиолдолд дараах арга хэмжээг авна:
 - 3.6.1. Энэ журмын 3.2-т заасан өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээлэл нь тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид мэдэгдэхүйц нөлөөлөхөөр бол энэ талаар судалж, холбогдох үндэслэл бүхий тайлбарыг Биржид хуанлийн 3 өдөрт мэдэгдэнэ.
 - 3.6.2. Компанийн удирдлага тухайн огцом өөрчлөлт нь үнэт цаас гаргагчийн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлнө гэж үзвэл энэ талаар олон нийтэд ажлын 1 өдөрт багтаан мэдээлнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ

- 4.1. Хувьцаа эзэмшигч нь компанийн албан ёсны цахим хуудсанд өөрийн цахим хаягаа бүртгүүлж, мэдээллээ авах боломжтой. Компани нь жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо, Хороо болон Биржийн дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр танилцуулна.
- 4.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, Компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, хуулбарлан авах бололцоог хувьцаа эзэмшигчид олгох үүрэг хүлээнэ. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад энэхүү үүргээ хэрэгжүүлэхэд нь Компанийн бусад холбогдох албан тушаалтан дэмжлэг үзүүлж, зохих боломжоор хангах үүрэгтэй.
- 4.3. Хувьцаа эзэмшигч мэдээлэл авах хүсэлтээ цахим шуудангаар ирүүлсэн тохиолдолд түүний шаардсан энэхүү журамд хориглоогүй мэдээллийг цахим шуудангийн хаягаар хүргүүлж болно.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН АРХИВ БҮРДҮҮЛЭХ, ХАДГАЛАХ

- 5.1. Компани нь олон нийтэд хүргэх мэдээллийг сонирхогч бүх этгээдэд Биржийн болон Компанийн цахим хуудсаар тогтоосон хугацаанд нэгэн зэрэг мэдээлнэ. Компанийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл 5 жилийн хугацаанд байршина.
- 5.2. Олон нийтэд мэдээлсэн баримт бичгийг 5 жилийн хугацаанд хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа тэдгээрийг архивт шилжүүлнэ.
- 5.3. Журмын 5.2-т заасан баримт бичгийг Компанийн холбогдох журмын дагуу хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг энэхүү журамд заасан мэдээллийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙГ НЭЭЛТТЭЙ БОЛГОХОД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ, ХОРИГЛОХ ЗҮЙЛС

- 6.1 Дотоод мэдээлэл эзэмшигч нь энэхүү Журамд заасны дагуу уг мэдээллийг нээлттэй болгохоос өмнө санаатай болон болгоомжгүйгээр бусдад мэдээлэх, дамжуулах, ашиглах,

бусад этгээд олж авах нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.

6.2 Дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд бүртгэлтэй үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслийн арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцсон бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэж, Хороо болон Биржид мэдэгдэнэ.

6.3 Компани нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

6.4 Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Биржээс нийтэд мэдээлэхээр тогтоосноос бусад, Байгууллагын нууцын тухай хуулийн дагуу Компанийн “байгууллагын нууц” гэж тогтоосон мэдээлэлд энэ журам хамаарахгүй.

ДОЛОО. БУСАД

- 7.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтөлж, эрх бүхий байгууллага, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэнэ.
- 7.2. Энэ Журмыг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Компанийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 7.3. Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээд эрүүгийн, захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран уг зөрчлийн улмаас компанид учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

---oOo---